

Монголын Шинэ Социал Демократ Намын Улс
Төрийн Ерөнхий Зөвлөлийн хурлаар батлав.

Айл хүний амь нэг
Саахалт айлын санаа нэг

**МОНГОЛЫН ШИНЭ СОЦИАЛ ДЕМОКРАТ НАМЫН
2000 ОНЫ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Манай намын үндсэн зорилго нь Монгол орныг үгээгүй ядуучуудгүй нийгмийн дээд доод давхрагын ялгарал нь Үндэсний дотоод хагарал, дайсагналыг төрүүлэх хэмжээнд хүртлээ хэзээ ч хурцдадгүй тогтвортой хөгжилтэй, бууралтгүй дэвшил бүхий ардчилсан орон болгохыг зорьж үжиллахад оршино. Энэ зорилгоо бнелүүлэхийн тулд сонгуулийн хугацаанд болон ойрын ирээдүйд дараах ажлыг санаачлан хийх болно.

1. Монголд өөрийн хөрөнгө болон гадаадын зээл тусламж, гадаадын хөрөнгө оруулалтаар экспортод чиглэсэн орчин үеийн техник, технологитой хөдөө аж ахуйн түүхий эдийг боолвсруулах, эцсийн бүтээгдэхүүн хийх мөн түүнчлэн байгалийн ашигт малтмалыг ашиглах үйлдвэрүүдийг байгуулах хууль зүйн таатай орчин бий болгох, төрөөс тэдгээрийг бүх талаар хөхүүлэн дэмжих.
2. Өмч хувьчлалаар хувьд шилжсэн бүх үйлдвэрүүдийн явц байдалд төрийн зүгээс үзлэг явуулж дахин сэргээх, шинэчлэн байгуулах талаар эзэмшигчидтэй нь гэрээ хэлцэл хийж хүчин чадлыг нь бүрэн гүйцэд ашиглахад анхаарал төвлөрүүлнэ.
3. Монгол орны тусгаар тогтнолд үлэмж ач холбогдол бүхий суурь үйлдвэр, дэд бүтцийн салбар зэрэгт төрийн өмч байхыг хүлээн зөвшөөрхийн зэрэгцээ тэдний ажил үйлчилгээг боловсронгүй болгох, улсад төлөх ашгийг бууруулахгүй харин ч нэмэгдүүлэх замаар гэрээ түрээсээр ажиллуулах, нэмэж хөрөнгө оруулан хувь нийлүүлсэн аж ахуйн нэгж байгууллага болгох зэрэгзэр үр ашигтай ажиллуулах.
4. Гадаад орнуудад өөрийнхөө байдлыг танин мэдүүлсэнээр мэргэжлийн өндөр чадвартай ажилтан бэлтгэх зорилгоор залуучуудыг гадаад орнуудын засаг төрийн байгууллагуудтай хийсэн гэрээ хэлэлцээрийн дагуу ажиллуулах.
5. Гадаад орнууд, ялангуяа зэргэлдээ хөрш орнуудын зах зээлийг судлах замаар тэдэнтэй хамтарсан үйлдвэрүүлийг байгуулах ажлыг төрөөс хөхүүлэн дэмжинэ.
6. Монгол орны алслагдсан аймгуудад шинээр ажлын байр бий болгох чинглэлээр байгуулагдсан үйлдвэр зарим үйлчилгээний газруудад гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийг хамааруулна.

7. Алслагдсан аймгуудад ажиллаж, амьдарч буй хүмүүст нэмэгдэл цалин, хангамж, тэтгэлэг бий болгох.
8. Монголдоо, ялангуяа түлш эрчим хүч, замын сүлжээ байгуулахад оруулсан дотоодын хөрөнгө оруулалтыг аливаа татвараас чөлөөлөх, барьж байгуулахад нь бүх талын туслалцаа дэмжлэг үүзүлэх.
9. Малын хашаа, худаг барих, сэлбэх засварлах, ноос ноолуурыг авах, сүү саалийг ашиглах, хадлан тэжээл бэлтгэх зэрэгт хөдөөгийн бүх залуучуудын хөдөлмөрийг баг бүрээс хорших замаар ашиглаж, улс, аймаг, сумдын хэмжээнд тэднийг шалгаруулан алдаршуулах, хөдөө аж ахуйн түүхий эдийг боловсруулах үйлдвэрүүдийг хамтран зохион байгуулах.
10. Малын гаралтай түүхий эдийг дотоодын боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлж, эцсийн ашиг хувиарлахад оролцуулах хууль зүйн орчинг бий болгохын зэрэгцээ баг, сумдад хөдөлмөр зохион байгуулалтын зохих бүтэц бий болгох ажлыг гүйцэтгэнэ.
11. Хөдөө орон нутгийн эмзэг асуудлуудын иэг болох малын хулгайг таслан зогсооход түлхүү анхаарч орон нутагт зохих дэд бүтцийг байгуулах замаар энэ асуудлыг зохицуулах болио.
12. Газар тариаланг хөгжүүлэх ажлыг зохион байгуулах хувь ийлүүлсэн аж ахуйн томоохон байгууллагуудыг бий болгох, тэдгээрийг гадаадын ижил төрлийн бараа болон татварын шахалт дарамтаас хамгаалах, үүний үндсэн дээр хүнсний ногоо, гурил тэжээлийн дотоодын хэрэгцээг үндсэнд нь хангах.
13. Гадаадын зээл тусламжийн зарим хэсгийг их далайд гарцтай болох, өөрийн хөлөг онгоцоор далайн хишиг хүртэхэд зориулж уг ажлыг зохион байгуулна.
14. Малчдыг хөдөлгөөнт радио телефеноор хангах талаар нэгдсэн бодлого явуулж аажмаар хэрэгжүүлнэ.
15. Малын үүлдэр угсааг сайжруулж хагас суурьшмал мал аж ахуйд шилжих үндэсний хөтөлбөр болolvсruулж олон улсын дэмжлэг авах ажлыг зохион байгуулах.
16. Сурах хүсэл, авьяастай боловч хөрөнгийн чадваргүй хүүхдийг их дээд сургууль, мэргэжлийн сургуулиудад үнэ төлбөргүй сургах ажлыг зохион байгуулах. Насанд хүрсэн бүх иргэдэд бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх.
17. Бүх хүмүүс эрүүл мэндийн даатгалын дагуу үнэ төлбөргүй эмчлүүлэх, иж бүрэн оношлогооны төвүүдийг бүсчлэн зохион байгуулах, мөн мэс

Монгол улс Зүүн Хойд Азид Солонгосын хойгийн хоёр улстай аль алинтай нь сайн харилцаатай байж, энэ бус нутгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, аюулгүй байдлыг тогтооход хувь нэмэр оруулахыг хичээнэ. БНСУ-тай улс төр эдийн засаг, нийгмийн салбарт харилцаагаа улам гүнзгийрүүлэн хөгжүүлэхийг чухалчилна.

Өнө эртний уламжлалт харилцаа бүхий Энэтхэгтэй хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, АНД-н бусад оронтой, тухайлбал Канад, Австрали, АСЕАН-ы гишүүн Тайланд, Вьетнам, Филиппин, Сингапур зэрэг оронтой харилцаагаа хөгжүүлэхэд түлхүү анхаарна.

Уламжлалт харилцаатай Төв ба Зүүн Европын орнууд, мөн Турк улстай хамтын ажиллагааг өргөжүүлэн,

экспортын зах зээлийг нээж өргөтгөх, хөрөнгө оруулалтын шинэ эх үүсвэртэй болох чиг баримтлана.

ТУХН-ийн улсууд, Төв Азийн орнуудтай худалдаа эдийн засгийн харилцааг сэргээх, тэдэнтэй өмнөх үеийн хамтын ажиллагааны нааштай өвийг бататгахын сацуу шинэ нөхцөлд нийцүүлэн хөгжүүлэх бодит боломжийг харгалзан уян хатан хандах бодлогыг цаашид ч баримтална.

НҮБ, ДХБ, АРФ зэрэг аюулгүй байдал, эдийн засгийн олон улсын байгууллагын олон талт үйл ажиллагаанд идэвхитэй оролцож, Монгол улсын нэр хүнд, байр суурийг бэхжүүлэх, үндэсний эрх ашгийг урагшуулахад чухал ач холбогдол өгнө.

Зүүн Хойд Азийн салбар бус нутагт өрнөж буй үйл явц манай үндэсний аюулгүй байдалд шууд нөлөөтэй. Иймд өөрийн хүчин чармайлтыг олон талт яриа хэлэлцээтэй зөв хослуулах замаар бус нутаг, салбар бус нутгийн тогтвортой байдлыг хангахад хувь нэмрээ оруулах чиг бодлого баримтлан ажиллана.

АПЕК-т нэгдэн орох нь Монгол улсын гадаад бодлогын урт хугацааны стратегийн зорилт хэвээр байх болно. Зэвсгийн хяналтын олон улсын дэг журмыг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулах нь манай улсын стратегийн зорилт хэвээр байна.

Улс орны аюулгүй байдлыг гадаад харилцаа, дипломат аргаар хамгаална.

Батлан хамгаалах зардлыг хорогдуулах бодлого баримтална.

Батлан хамгаалах хүчнийг иргэний хамгаалалт, хилийн цэрэг голлосон бүтцэд шилжүүлнэ.

Хилийн цэргийг бие даалгаж, агентлаг болгоно.

Илүүдэлтэй байгаа зэвсэг техникийг зарж борлуулах замаар орчин үеийн бүтээмж өндөртэй техник хэрэгсэл авах боломжийг бүрдүүлнэ.

Монгол үндэстний зан заншил, уламжлал, шашин, хэл, соёл зэрэг үндэсний ой мэдрэмж, дархлааг хамгаалах асуудлыг үндэсний аюулгүй байдлын нэг тулгуур гэж үзнэ.

Ан сонгуулийн мөрийн хөтөлбөр

Нарийн мэргэжлийн тусламжийг эрүүл мэндийн, хувийн нэмэлт даатгалаар дэмжих хууль эрх зүйн орчин
буюу уулз.

Хүчинчийн байгууллагаар гарзажээр гүйцэтгүүлэх чиглэл

Үүшиг булагийн хөгжлийн асуудал

Нийтийн тэнцвэрт байдлыг хангах үндэсний стратегийг боловсруулж хугацаат цэргийн алса, цагдаагийн анбанд 3-аас доошгүй жил ажиллагсдыг иргэний боловсрол олгох сургалтанд хамруулахыг төрөөс дэмжинэ. Кун амын механик шилжилт хөдөлгөөний хурдыг сааруулах, зах хязгаарын эзэнгүйдлээс сэргийлэх бодлогоо боловсруулж хэрэгжүүлнэ.

Хүнний эзлэхэд тухайн хүний халдашгүй эрх гэж үзнэ.

Хүний орон сууц барихад зориулсан зээлийн хэмжээг нэмэгдүүлнэ.

гамэр зам зэрэг хамтарсан үйлдвэрийн мэдлийн орон сууцыг эзэмшиж чадэж нь чадац болжээ.

Шийжлэх ухаан, боловсрол, соёлын хүрээнд

хуван, боловсролыг тэргүүлэх чиглэл гэж үзнэ.

ПОДГОТОВКА УЧАЩИХСЯ

БСЧ-д хөдөлгөмжийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтэнд нөлөөлж чадахуйц ажилчин бэлтгэх мэргэжлийн түршлэлийн уян хатан тогтолцоог бий болгоходо техникийн нарийн мэргэжил олгох сургалтыг хэрэгжүүлэх шинийн баримтлана.

Банш нарыг давтан сургаж, эрдэм шинжилгээний ажилд өргөнөөр оролцуулах, сурган хүмүүжүүлэх урлагийн байнга дээшлүүлэх талаар тодорхой хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

Уснын сургуулиудыг менежментийн хувьчлалд хамруулах асуудлыг судалж шийдвэрлэнэ.
Дэд боловсролын тогтолцоог тухайн салбарт судлаачийн хэмжээний боловсролтой мэргэжилтэн бэлтгэхэд
жинчилжээ.

Нийтийн хүрээгүй хүүхдүүдийг боловсролд бүрэн хамруулах чиглэлээр зорилтот хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ. Нийтийн хүрээгүй хүүхдүүдийг орнуудад иргэдээ сургах, мэргшүүлэх чиглэлийг түлхүү баримтална.

Минийх ухаан

Шинжлэх ухаанд төр гол захиалагч байх боллогыг баримтлана.

Шинжлэх ухаан, хувийн хэвшилийн харилцан ашигтай хамтын ажиллагааг бүх талаар дэмжиж.

Түндэсний технологийг шинэчлэн сайжруулах, гадаадын шилдэг технологи нэвтрүүлэх явдлыг үндэсний агуулгүй байдал, тогтвортой хөгжлийн нэг үндэс гэж үзэж төрийн анхаарал ивээлд авна.

Шинжүүчийн ухаан, технологийн нэгдсэн сүлжээг бий болгож, олон улсын мэргэжлийн сүлжээнд холбосно.

— 10 —

Хамаа бүтээгчийн бүтээл түүрвил, мэргэжлийн ур чадварын үнэлгээг дээшлүүлнэ.

Хийн бүтээлчдийн бүтээл түүрвийг, мөр
түүрээс худалдаж хийнчилж, тийн чадлыг
худалдаанд олон нийтийн төслийг хийнчилж,

Сүйлөгдүүртэй төрлийн извээлд альна.

Ганц шийяастныг дэмжин, өндөр ур чадвартай уран бүтээсэн дээрээсээ бол хүчний төлөөлгөөнүүдэдээсээ бол урлагийг зах зээлийн зарчимд нийцүүлэн боловсронгуй болгож, үүнд оруулж байгаа хөрөнгө оруулалтыг татнарын бодлогоор дэмжинэ.

Гадаад бодлого, аюулгүй байдлын хүрээнд

Засгийн газар дэлхийн бүх улс оронтой улс төр, нийгэм эдийн засгийн тогтолцоо ялгаатайг үл түүх, шашин, соёл, үндэсний ёс заншлыг хүндэтгэн, харилцан бие биенээ гүнзгий танин мэдэх, итгэлцлийг бэхжүүлэх замаар найрсаг харилцаа, эрх тэгш харилцан ашигтай хамтын ажиллагааг чиглэсэн олон тулгуурт, нээлттэй гадаад бодлогыг нэдмэл бөгөөд залгамж чанаараар нь чиглэгдэн явуулна.

ОХУ, БНХАУ- тай тогтоосон найрсаг сайн хөршийн харилцаа хамтын ажиллагааг урт хугацаанд тэнцвэртэй , эх тэгш, харилцан ашигтай байх зарчмын дагуу өргөжүүлэн гүнзгийрүүлэх чиг шугамыг тууштай

Баримтлана.
Түүн нутаг , дэлхийн нелөө бүхий орнуудтай харилцааг түлхүү хөгжүүлж , аль болох анд нөхөд , дэмжигчидтэй
бүлэгтэй эрмэлзэнэ. Монгол улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн шинэ замналыг бататгаж , зах зээлийн
засагт шилжих уйл явцыг түргэгтэхэд өрнө дорны өндөр хэгжилтэй гүрнүүдийн сэтгэл санаа, улс төр,

Им хүч, цахилгаан

Үнэмжлалт болон шинэ эх үүсвэрүүдийг нэвтрүүлж хөгжүүлэх замаар дулаан хангамж, эрчим хүчиний талаар шийдвэртэй арга хэмжээ авна.

Орчим хүчиний найдвартай эх үүсвэрүүдийг бий болгох үндсэн нөхцлийг бүрдүүлэх замаар орон нутгийн 80 түүвийг эрчим хүчээр хангана.

Эгийн гол, Чоно голын усан цахилгаан станцын хөрөнгө оруулалт, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэж, барилгын ажлыг эхлүүлнэ.

Нефть, байгалийн хий ашиглалтын соёлыг нэвтрүүлнэ.

Мяг аж ахуй

Малчдын хөдөлмөрөө хорших, зах зээлийн үнэ ханшийн мэдээлэл авах, малаа даатгуулах, цөөн малтай ширхэд мал түрээслүүлэх явдлыг дэмжих замаар малчдыг төрийн бодлогын анхаарлын төвд байлгана.

Малын ашиг шим, үүлдэр угсааг сайжруулж сургийн бүтцийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тодорхойлон тохиоос чанарт шилжүүлэх цогцолбор арга хэмжээ авна.

Мяг сургийг эрүүлжүүлэх талаар үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

Мяг аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлд даатгалын тогтолцоог буй болгон орчин үеийн төхник технологи, мэдээлэл холбооны сүлжээг бий болгоно.

Нийгмийн хүрээнд**Идуурлыдэл ядуурал**

Хөдөлмөрийн чадвартай хүн амыг ажил эрхлэлтэнд бүрэн хамруулах чиглэлээр үндэсний бодлого ицуруулна. Ингэхдээ:

Ажлын байр олноор бий болгох үйлчилгээний чиглэлийг түлхүү хөгжүүлнэ. Нийгмийн салбарт оруулж байгаа төрөнгө оруулалт, гадаадын зээл тусламжийн тодорхой хэсгийг шинээр ажлын байр бий болгоход чиглүүлнэ. Ажлын байрыг олноор бий болгож байгаа хувийн хэвшлийн байгууллагуудад төрийн зүгээс дэмжлэг үзүүлдэг механизм бүрдүүлнэ.

Ажилгүйдлийн даатгалын тогтолцоог хөдөлмөрийн албадыг түшиглүүлэн бий болгож, мэргэжлийн болон цийнтан сургалтыг түлхүү санхүүжүүлэх чиглэлээр хөгжүүлнэ.

Ажлын байрыг олноор шинээр бий болгож байгаа аж ахуйн нэгжийг урамшуулах хууль гаргана.

Орон нутагт ажлын байр шинээр бий болгох үндэсний хөтөлбөр боловсруулж, санхүүжилтийн эх үүсвэрийг шийднэ.

Идуурлыг бууруулах стратегийг нийгмийн асуудал гэхээсээ илүү хүнийг хөгжүүлэх хандлагаар тодорхойлж, барилгын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхдээ амьжиргааны чадавхийг нэмэгдүүлэх, орлого нэмэгдүүлэх чиглэлийг түлхүү баримтална.

Идуурлаас урьдчилан сэргийлэх асуудал үйл ажиллагааны нэг чухал стратеги байх болно.

Хүүхдийн хөдөлмөрийн хүнд, тэвчишгүй хэлбэрүүдийг устгана.

Цалин хөлсийг амьжиргааны орлогын гол эх үүсвэр байхаар тогтоож, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь амьжиргааны төвшний доод хэмжээний 1,5 дахинаас багагүй байхаар тогтооно.

Илангуяа эрүүл мэнд, боловсрол, соёл урлаг, үйлчилгээний салбарт ажиллагсдын цалинг төрөөс тогтоохыг тогталзаж дотооддоо хамтын гэрээ хэлцлээр тогтоох зарчимд шилжүүлнэ.

Үлс төр, төрийн тусгай алба, төрийн захиргааны албадын цалин хөлс нь тэдгээрт ажиллагсдын нийгмийн биталгааг бүрэн хангахуйц, аливаа авилгал, нэмэлт орлогын ашиг сонирхолоос ангид байхад нелөөлөхүйц хэмжээнд тогтооно.

Тэтгэвэр тэтгэмж

Тэтгэврийн даатгалын тогтолцоог үе шаттай хувьчилж, хувийн даатгалын тогтолцоо бие даан хөгжих чиглэлийг тууштай дэмжиж, даатгууллагчдын ирээдүйн ашиг сонирхол баталгаатай байх чиглэлээр шинчлэлийг гүнзгийрүүлнэ.

Тэтгэвэр, тэтгэмжийн дундаж хэмжээг хоёр дахин өсгөнө.

Наглан хамгаалах болон хүчиний байгууллагад ажиллаж буй төрийн тусгай албан хаагчдын тэтгэврийн асуудлыг тусгай хуулиар зохицуулна.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөл, хөдөлмөрийн таагүй нөхцлөөс үүдэлтэй аливаа көнгөлөлт, тэтгэвэр тэтгэмжийн асуудлыг ажил олгогч бүрэн хариуцах чиглэл баримтална.

Гор бүлийн даатгалын тогтолцоо бүрдүүлэх асуудлыг судалж олон хүүхэдтэй гэр бүлд сар бүр тэтгэлэг олгох механизм бүрдүүлнэ.

Нийгмийн халамжийн үйлчилгээний санхүүжилтийг аль болох орон нутаг хариуцах чиглэлээр өөрчлөх, хөрөнгийн дутагдалтай аймгуудад нэмэлт санхүүжилтийг хөрөнгө оруулалтаар дамжуулан олгох чиглэл баримтлана.

Нийгмийн салбарын үйлчилгээний өртөг зардлыг хямдруулах, үйлчилгээг чирэгдэлгүй шуурхай болгох чиглэлээр бүтцийн өөрчлөлтийг хийнэ.

Бүрэн тэтгэврийн болон сар бүр олгодог тэтгэмжийн доод хэмжээ амьжиргааны төвшинг хангахуйцаар бийна.

Өмэгтэйчүүд, хүүхэд, залуучууд, өндөр настан, тахир дутуу иргэдийн нийгмийн хамгааллын асуудлыг тэдний эрх ашигийг хамгаалах байгууллагын санал, хүний хөгжлийн асуудалтай уялдуулан шийдвэрлэх үндэсний төсөл, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

Үүр мэнд

Зорилт майданийн улсынгасийн шаталыг тогтоож эмчилгийн сүхдэлтийн олонхицтэй

Эдэлж үүргээ биелүүлэх зан төлөвийг иргэдэд төлөвшүүлэх, төрийн, олон нийтийн байгууллага, түүүн, гэр бүлийн хүрээнд хүчирхийлэл, садар самууныг үл тэвчих сэтгэлгээг туштай бий болгоно. Төрчийн хувьчлах нь: Улс төрийн гэхээс илүү хүний эрхийн баталгааг хангаж буй гол асуудлын нэг гэж үзнэ.

Эдийн засгийн хүрээнд

Эдийн засгийн тогтвортой өсөлтийн үндсийг бүрдүүлэхэд чиглэсэн татвар, төсөв, мөнгө санхүү, зээлийн баримталж эдийн засгийн өсөлт нь хувь хүний амьдралаа дээшлүүлэх үндсэн дээр тогтоно.

Татвар

Татварын хуулийг боловсронгуй болгож, Монгол улс татвар нь тогтвортой байх чиглэл баримтална.

Наг татвар төлөгчид ногдох татварын хувь хэмжээг бууруулж татвар төлөгчдийн тоог нэмэгдүүлэх замаар төсвийн орлогыг бүрдүүлнэ. Татвар төлөгчдийн тоог 1,7 дахин нэмэгдүүлнэ.

Татварын ачааллыг 2004 он гэхэд 45% бууруулсан байна.

Татварын чөлөөлөгдхөн орлогын доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлж татварын нэр төрлийг цөөлнө.

Импортын барааны гааль худалдааны татварыг нэг мөр цэгцтэй болгож энэ талаар төрийн бодлогыг тогтоорой болгоно.

Ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварыг их бага орлого олсноос үл хамааран жигдруулж татварыг 15 хувьд хүргэж нэг шатлалтай болгох нь шудрага ёсонд нийцнэ гэж үзнэ.

Төслийг хадгаламжийн орлогын татвараас чөлөөлнө.

Татварын аливаа давхардлыг арилгана.

Чинжилж ухаан, төхнөгийн дэвшигийг татварын бодлогоор урамшуулна.

Татвар ногдуулалт, төлөлтөнд тавих хяналтыг сайжруулж татвараас зайлсхийх явдалтай туштай тэмцэж, тавихаархи хууль эрх зүйн актыг боловсронгуй болгоно.

98

Төслийн орлогыг нэмэгдүүлэх, төсвийн зарлагын бүтцийг оновчтой болгож төсвийн ачааллыг улс орны эдийн засгийн нөөц боломжид тулгуурлан тодорхойлж байх зарчим баримтална.

Төслийн байгууллагуудыг санхүүжүүлэх шалгуур үзүүлэлтүүдийг тогтоож төсөв захиран зарцуулах, удирдах үйл ажиллагааны мөнөхмөнтийг сайжруулах бодлого баримтална.

Төслийн байгууллагуудыг санхүүжүүлэхдээ төрийн үйлчилгээний үүргийг биелүүлсэн үр дүнгээр санхүүжүүлэх төслийн баримтлана.

Төслийн зардлын норм, нормативийг боловсронгуй болгоно.

Олон нутгийн төсөвт олгох татаасыг багасгаж орон нутаг бие даан ажиллах боломжийг нэмэгдүүлнэ.

Төслийн алдагдлыг дотоодын нийт бүтээгдэхүүний 5%-иас хэтрүүлэхгүй байх зорилт тавина.

Төслийн зарлагад төрөөс тавих хяналтыг эрс сайжруулж төсвийн урсгал тэнцлийг баталгаажуулж, төсвийн оруулалтыг нэмэгдүүлэх арга хэмжээ авна.

Төслийн орлого зарлагын бүртгэлийг сайжруулах арга хэмжээ авна.

Төрийн мөнгөний тогтвортой бодлогын төлөө байна.

Төслийн валютын нөөцийг 200 сая ам долларт хүргэнэ.

Төслийн ханшийг тогтвортой байлагах бодлого баримтлана.

Арилжааны банкуудын үйл ажиллагаанд иргэдээс тавих хяналтыг ил тод шудрага болгоход чиглэсэн хууль гаргана.

Банкинаас зээл аваад хугацаанд нь төлөөгүй хүмүүсийг баг хороо, сум дүүрэг, аймаг хот, УИХ, Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигүүлэхгүй байх, төрийн захиргааны байгууллагад ажиллуулахгүй байх боломжийг бүрдүүлнэ.

Татвар тусlamжийн мэдээллийн нэгдсэн сантай болж, зээлийг үр ашигийн салбарт, хөгжлийн албан ёсны тусlamжийн нийгмийн салбарт үр ашигтай ашиглана.

Татвар тусlamж, хөрөнгө оруулалтанд тавих төрийн хяналтыг сайжруулна.

Олон нутгийн хүрээнд зөвлөн дэд бүтцийг бий болгох боломжийг судалж, туршилтын журмаар хэрэгжүүлнэ.

Дотоодын хөрөнгө оруулагчдыг дэмжих бодлого баримтална.

Хувьчлал

Газар хувьчлалын бүх талын зохистой хэлбэрийг хөхүүлэн дэмжиж, үр ашигтай удаан хугацаанд эзэмших ашиглалтад захиран зарцуулахын төлөө байна. Монгол улсын иргэдэд хэрэглээний газрыг үнэ төлбөргүй үүнчилнэ.

Хувьчлалын эзэмшигчдийн эрх ашигийг хамгаалсан бодлого баримтлана.

Хувьчлалын эзэмшигчдийн үлдсэн болон хамтарсан байгууллагуудын орон сууцны хувьчлалыг үргэлжлүүлнэ.

Гомиж ахуйн нэгжийн монопол эрхийг хязгаарлаж хувьчлахын төлөө байна.

Лүүнэц

Дэд бүтцийг хөгжүүлэх явдал төрийн анхааралд байна. Үүнийг тэр болон хувийн секторын түншлэл, олон үзүүлийн болон бус нутгийн байгууллагуудын хамтын хучин чармайлтаар шийдвэрлэх нь оновчтой гэж үзнэ.

МОАН- 2000 ХӨТӨЛБӨР
СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Бидний уриа :

ХҮЧТЭЙ ТӨР- ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ- ХАНГАЛУУН АМЬДРАЛ.

Үүний тулд иргэн бүр өөрийнхөө төлөө ажиллаж, хувь заяагаа өөрөө бүтээж, арчиллыг түнзгийрүүлэх, эх Монгол орноо дэлхийн хөгжингүй орууудын жишигт хүргэхэд үр дүнтэй хувь нэмэрээ аруулах чин хүсэл эрмэлзэлтэй байх ёстой. Энэхүү болзлыг Та хүлээн зөвшөөрвөл бид:

Улс төрийн шинэчлэлийн хүрээнд:

Хууль тогтоох эрх мэдэл

- Үндсэн хуулийн тогтвортой байдал, төрийн бодлогын уламжлал, залгамж чанарыг хадгална. Хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах чиглэлд өөрчлөлт оруулах асуудал нээлттэй байх бөгөөд энэ асуудлыг нийгмийн хүрээнд зөвшилцлийн зарчмаар шийдвэрлэж байхыг хуульчилна.
- Үндсэн хуулийн үзэл санаанд нийцсэн төрийн тогтолцоог хөгжүүлэх, төлөвшүүлэхэд нөлөөлөх суурь хуулиуд, тухайлбал сонгуулийн болон улс төрийн намуудын тухай хуулийг арчиллын зарчимд нийцүүлэн өөрчилнэ.
- УИХ-ын үйл ажиллагааг сонгогч олны санаа сэтгэлд нийцэхүйц боловсронгуй болгож, гишүүдийн үйл ажиллагаа сонгогчдод нээлттэй байхыг чухалчилна. Үүний тулд УИХ-ын гишүүн аливаа асуудалд саналаа нээлттэй өгөх, хаалттай хуралдаанаас бусад хуралдаануудыг төлөвизийн сувгаар тогтмол үзүүлж байхыг арчиллын ердийн хэмжээ гэж үзнэ.
- Ард түмнээс хүлээсэн итгэлээр төлөөлөгдсөн парламентат ёсыг цаашид бэхжүүлнэ.
- Нийгмийн тогтвортойг байдлыг тухайн асуудлыг бүрэн шийдвэрлэх чадвар, эрх бүхий төрийн институтуудын хүрээнд шийддэг байх механизмыг бий болгоно.
- Эрх зүйн шинэтгэлийг түргэлгэж, эхний ээлжинд чухал шаардлагтай байгаа 100 хуулийг боловсруулан УИХ-аар хэлэлцүүлнэ. Үүнд иргэний болон эрүүгийн, эрүүгийн байцаан шийтгэх, банк санхүүгийн тогтолцооны хямралыг гэтлэн давах, авилгалгүй орчин бүрдүүлэх, ажлын байр шинээр бий болгохыг дэмжихэд чиглэсэн хуулиуд орно.

Гүйцэтгэх эрх мэдэл

- Мэргэжлийн өндөр ур чадвартай, асуудлыг шийдвэрлэх эрх мэдэл бүхий, Төрийн албан хаагчийн онцгой шалгуур, болзол, нөхцлийг хангасан боловсон хүчинээс бүрдсэн цомхон, чадварлаг бүтцүүдийг бий болго замаар Засгийн газрын бүтэц, үргийг төгөлдөржүүлнэ. Төрийн ажилтны цорын ганц шалгуур нь мэдлэг, боловсрол, чадвар, туршилага болохоос улс төрийн үзэл бодол, намын харьялал биш гэдэг зарчмыг туштай хэрэгжүүлнэ.
- Банкны хугацаа хэтэрсэн зээл, татварын өртэй хүмүүсийг төрийн улс төрийн болон захирагааны албан тушаалд ажиллуулах явдлыг бүрэн зогсооно. Тухайн албан тушаалд байгаа хүн ийм асуудалд холбогдол түүнийг авилгалд илүү өртөмтгийн бүлэгт хамааруулж, төрийн албан хаагчийн шалгуур үзүүлэлтийг хангаагүй гэж үзнэ.
- Төрийн дотоод хяналтын оновчтой тогтолцоог бий болго замаар гүйцэтгэх засаглал, төсвийн зарцуулалтанд тавих хяналтыг өндөржүүлнэ. Төсвөөс зээл олгохыг таслан зогсооно.
- Төрийн байгууллагыг зөвшөөрлийн тогтолцооноос бүртгэлийн тогтолцоонд шилжүүлнэ.
- Орон нутгийн өөрөө удирдах ёсыг цаашид бэхжүүлж, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг тууштай нэвтрүүлнэ. Үүний тулд боловсролын байгууллагуудад төсвөөс оруулж байгаа хөрөнгийг хөрөнгө оруулалтын бүтцэд баатаана.
- Баруун, төв, эрчимтэй хөгжлийн, зүүн гэсэн дөрвөн бүс болгож бүс нутгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тогтооно.
- Төрийн ажилтнуудаас авилгалд өртөх, гэмт хэрэг үйлдэх, ёс суртахууны зөрчил гаргах явдлыг таслан зогсох цогц мөханизмыг бий болгоно. Үүний тулд авилгалтай тэмцэх үндэсний хороог УИХ-ын дэргэд байгуулна.
- Эрх зүйн шинэтгэлийг хуулиар хориглоогүй бол нээлттэй байдаг чиглэлээр гүнзгийрүүлнэ.
- Шүүхийн шинэчлэлийг иж бүрэн хэрэгжүүлэх, шүүгчдийн бие даасан байдлыг хангах иж бүрэн мөханизмыг бүрдүүлэхийн зэрэгцээ хуулиар хүний эрхийг хязгаарлах эрх мэдэл олгосон цагдаа, хэрэг бүртгэгч, мөрдөн байцааг зэрэг албан тушаалтныг давтан сургах, хараат бус байдлыг нь дээшлүүлэх талаар тусгай хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- Эрүүгийн эрх зүй, байцаан шийтгэх ажиллагаанд хүний эрхийг баталгаажуулах чиглэлээр өөрчлөлт оруулна.
- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг дахин боловсруулж, Үндэсний төлөвиз радиог олон нийтийн мэдэлд бүрэн шилжүүлнэ.
- Хүний эрхийн үндэсний байгууллагыг хуулийн дагуу байгуулж, олон улсын ижил төстэй байгууллагуудын холбоонд элсүүлнэ.
- Шүүхийн шийдвэр заавал биелэгдэх тогтолцоог бүрдүүлж, хуулийн хариуцлагаас зайлсхийгчдэд хүлээлгэх хариуцлагаыг чангатгах, иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэлийн үйл ажиллагааг биелэлтийн үр дүнгээр санхүүжих чиглэлээр эрх зүйн үндсийг боловсронгуй болгоно.
- Зах зээлийн эдийн засгийн харилцаанд гарч буй шинэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар эрх зүй-зохион байгуулалтын оновчтой арга хэмжээ авна.
- Гэмт хэрэгтэй тэмцэх ажлын үр дүнг зонхилох гэмт хэргийн илрүүлэлт, бууралтын түвшинг харгалзан тогтоох

заслын болон эмчилгээний өндөр мэргэжил эзэмшилсэн эмч нарын группийг бий болгон тэдгээрийн нийгмийн асуудлыг бүрэн шийдвэрлэх, доноорын хуулийг яаравчлан батлуулж, зохион байгуулах.

18. Хилийн цэргийг бэхжүүлэх, тусгаар тогтиолоо хамгаалах үндэсний бодлогыг хэрэгжүүлэх ажлыг эрчимтэй зохиох.
19. Банкны сүлжээг зөв зохион байгуулж, банк санхүүгийн өнөөгийн хямралыг арилгаж бэлэн бус тооцоог өргөн нэвтрүүлэх арга хэмжээг зохион байгуулж, төгрөгөөр улсын эдийн засгийн өсөлт хөгжилтөд тавих хяналтыг хүчтэй болгох. Нөгөө талаар үйлдвэр үйлчилгээг хөгжүүлэхэд чиглэсэн гадаадын банк санхүүгийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх.
20. Гадаадын зарим оронд газрыг удаан хугацааны түрээсээр эзэмшиүүлэх ажлыг судлаж олон түмнээр хэлэлцүүлэх.
21. Удирдлагын цомхон чадварлаг алба бий болгож, зардлыг 50-иас доошгүй хувиар хамдруулан орон нутгийн удирдлагыг бэхжүүлэх.
22. Аюулгүй, ариун цэвэрч орчинд ажиллах, амьдрах нөхцөлийг бий болгоход ард иргэдийн оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээ боловсруулж хуульчлах.
23. Олон улсын гадаад харилцааны төрийн уламжлалыг хадгалах, ялангуяа ОХУ, БНХАУ-тай байгуулсан хамтын ажиллагааг бүх талаар сэргээнэ.